

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд сумын цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2026/148/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ны аудитор: Д.Хишгээ Утас:99964238 Цахим хаяг: nishge.da@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Төлбөрийн акт	9
3.1.1 Хувь хүний орлогын албан татвартай холбоотой асуудал	9
3.2 Зөвлөмж	10
3.2.1 Хүүхдийн ирцийн бүртгэлтэй холбоотой асуудал	10
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	12
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	12
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2025.02.23 № 124

танай _____-ны № _____-т

ХОВД АЙМГИЙН ХОВД СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.ШОЛПАНХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд аймаг, сум орон нутгийн хөгжлийн сангийн 53.3 сая төгрөгний хөрөнгө оруулалтын ажил хийгдэж багш ажилчид, хүүхэд багачуудыг ажиллах сурч хөгжихөд ая тухтай орчин бүрдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Ховд аймгийн Ховд сумын хүүхдийн цэцэрлэгийн төсвийг 2025 онд хоёр удаа тодотгол хийж, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 31.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн санхүүгийн дэмжлэгийг 14.4 мянган төгрөгөөр бууруулж, оны эцэст 0.3 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулахгүйгээр төсөвт төвлөрүүлсэн байна.

8426050249
A4-Тоот-2026

Бусад асуудлын хэсэг

2025 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 зорилтын хүрээнд 64 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн, дэвшүүлсэн зорилт гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 92.5 хувиар үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	135,222,532.45	43,099,410.53
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	117,944,510.45	21,201,184.53
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	117,944,510.45	21,201,184.53
3121	Төгрөг	117,944,510.45	21,201,184.53
31211	Төрийн сангийн харилцах	117,944,510.45	21,201,184.53
33	АВЛАГА	560,000.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	560,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	16,718,022.00	21,898,226.00
354	Хангамжийн материал	16,718,022.00	21,898,226.00
35410	Бичиг хэргийн материал	-	100,000.00
35420	Аж ахуйн материал	2,354,800.00	7,853,394.00
35460	Хүнсний материал	5,849,512.00	6,026,772.00
35470	Бусад хангамжийн материал	8,513,710.00	7,918,060.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	236,542,431.54	276,656,753.41
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	236,542,431.54	276,656,753.41
392	Биет хөрөнгө	228,588,631.54	268,702,953.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	170,272,480.00	170,272,480.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(17,027,248.32)	(19,865,123.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52,347,086.00	57,159,586.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,605,122.20)	(31,426,155.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,592,682.82	57,893,642.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,331,437.40)	(22,311,370.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,268,990.00	67,141,698.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,412,628.36)	(10,645,634.16)
39217	Ном	483,829.00	483,829.00
393	Биет бус хөрөнгө	7,953,800.00	7,953,800.00
39301	Програм хангамж	457,000.00	457,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,496,800.00	7,496,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	371,764,963.99	319,756,163.94
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,080,687.62	4,929,283.67
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,080,687.62	4,929,283.67
413	Өглөг	3,080,687.62	4,929,283.67
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,080,687.62	4,829,283.67
4136	Бусад өглөг	-	100,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	100,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	368,684,276.37	314,826,880.27
51	Засгийн газрын хувь оролцоо	368,684,276.37	314,826,880.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	58,437,248.00	58,437,248.00
51101	Өмч: - төрийн	58,437,248.00	58,437,248.00
512	Хуримтлагдсан үр дүн	198,841,507.57	144,984,111.47
51210	Өмнөх үеийн үр дүн	198,841,507.57	199,141,507.57
51220	Тайлант үеийн үр дүн	-	(54,157,396.10)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	111,405,520.80	111,405,520.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	371,764,963.99	319,756,163.94

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	684,209,300.0	769,845,862.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	655,297,400.0	769,845,862.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	601,497,900.0	660,777,100.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	601,497,900.0	660,777,100.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,641,200.0	60,248,162.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,641,200.0	60,248,162.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,158,300.0	48,820,600.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,158,300.0	48,820,600.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	590,982,386.6	824,003,258.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	590,982,386.6	824,003,258.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	590,581,357.8	818,942,949.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	447,802,509.5	603,769,029.8
210101	Үндсэн цалин	378,494,125.2	366,102,300.0
210102	Нэмэгдэл	69,308,384.3	193,871,014.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	11,775,000.0
210104	Урамшуулал	-	32,020,715.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,531,031.0	75,347,232.2
210201	Тэтгэврийн даатгал	18,723,531.0	51,730,085.4
210202	Тэтгэмжийн даатгал	449,200.0	6,031,413.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	393,000.0	3,015,706.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,291,400.0	2,911,511.0
210205	Эрүүл мэндийн даатгал	673,900.0	11,658,515.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,422,671.2	46,299,181.3
210301	Гэрэл, цахилгаан	3,098,494.2	4,796,004.3
210302	Түлш, халаалт	44,204,177.0	41,503,177.0
2105	Нормативт зардал	46,984,290.0	48,719,160.0
210502	Хоол, хүнс	46,984,290.0	48,719,160.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	2,166,400.0
210604	Урсгал засвар	-	2,166,400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	2,948,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,948,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,330,856.1	39,693,946.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,389,350.0	17,589,850.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,026,100.0	5,002,650.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,915,406.1	17,101,446.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	401,028.8	5,060,308.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	4,705,290.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	4,705,290.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	401,028.8	355,018.7
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	401,028.8	355,018.7
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	93,226,913.4	(54,157,396.1)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	93,226,913.4	(54,157,396.1)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		

Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	655,297,400.0	712,597,700.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	655,297,400.0	712,597,700.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	601,497,900.0	660,777,100.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	601,497,900.0	660,777,100.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,641,200.0	3,000,000.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,641,200.0	3,000,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	47,158,300.0	48,820,600.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	47,158,300.0	48,820,600.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	578,251,452.9	809,341,025.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	578,251,452.9	809,341,025.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	577,850,424.1	803,757,907.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	410,133,632.9	603,072,800.0
210101	Үндсэн цалин	266,317,529.6	366,102,300.0
210102	Нэмэгдэл	139,123,100.0	193,174,784.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	11,775,000.0
210104	Урамшуулал	4,693,003.4	32,020,715.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,806,800.0	72,812,055.9
210201	Тэтгэврийн даатгал	38,628,600.0	48,689,055.9
210202	Тэтгэмжийн даатгал	4,544,600.0	6,030,700.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,272,300.0	3,015,400.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,272,300.0	3,015,400.0
210205	Эрүүл мэндийн даатгал	9,089,000.0	12,061,500.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,517,271.2	46,299,181.3
210301	Гэрэл, цахилгаан	2,948,494.2	4,796,004.3
210302	Түлш, халаалт	41,503,177.0	41,503,177.0
2105	Нормативт зардал	35,724,420.0	48,896,420.0
210502	Хоол, хүнс	35,724,420.0	48,896,420.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,240,000.0	2,166,400.0
210604	Урсгал засвар	1,240,000.0	2,166,400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,140,300.0	3,402,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,804,500.0	3,402,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,288,000.0	27,109,050.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,227,400.0	22,039,400.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,060,600.0	5,069,650.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	401,028.8	5,583,118.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	5,228,100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,228,100.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	401,028.8	355,018.7
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	401,028.8	355,018.7
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	77,045,947.1	(96,743,325.9)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	77,045,947.1	(96,743,325.9)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		117,944,510.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	117,944,510.5	21,201,184.5

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,467,248.0	111,405,520.8	105,614,594.1	276,487,362.9
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59,467,248.0	111,405,520.8	105,614,594.1	276,487,362.9
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	93,226,913.4	93,226,913.4
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,467,248.0	111,405,520.8	198,841,507.6	369,714,276.4
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	59,467,248.0	111,405,520.8	198,841,507.6	369,714,276.4
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	300,000.0	300,000.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59,467,248.0	111,405,520.8	199,141,507.6	370,014,276.4
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(54,157,396.1)	(54,157,396.1)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,467,248.0	111,405,520.8	144,984,111.5	315,856,880.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	815,389,200.0	809,341,825.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	815,389,200.0	809,341,825.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	810,161,100.0	804,113,725.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	603,072,800.0	603,072,800.0
210101	Үндсэн цалин	377,877,300.0	366,102,300.0
210102	Нэмэгдэл	201,847,400.0	193,174,784.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	11,775,000.0
210104	Урамшуулал	23,348,100.0	32,020,715.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,063,500.0	72,812,055.9
210201	Тэтгэврийн даатгал	50,940,500.0	48,689,055.9
210202	Тэтгэмжийн даатгал	6,030,700.0	6,030,700.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,015,400.0	3,015,400.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,015,400.0	3,015,400.0
210205	Эрүүл мэндийн даатгал	12,061,500.0	12,061,500.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,655,000.0	46,655,000.0
210301	Гэрэл, цахилгаан	5,141,400.0	5,151,823.0
210302	Түлш, халаалт	41,513,600.0	41,503,177.0
2105	Нормативт зардал	53,233,500.0	48,896,420.0
210502	Хоол, хүнс	53,233,500.0	48,896,420.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,166,400.0	2,166,400.0
210604	Урсгал засвар	2,166,400.0	2,166,400.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,070,000.0	3,402,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,963,200.0	3,402,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,899,900.0	27,109,050.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,936,700.0	22,039,400.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,963,200.0	5,069,650.0

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,228,100.0	5,228,100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,228,100.0	5,228,100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,228,100.0	5,228,100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	815,389,200.0	712,598,500.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	815,389,200.0	660,777,100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	661,203,500.0	660,777,100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	51,821,400.0	51,821,400.0
132001	Орон нутгийн төсвөөс	51,821,400.0	51,821,400.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	102,364,300.0	117,944,510.5
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		21,201,184.5

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 109,267.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 104,673.3 мянган төгрөгийн бүртгэл, тайлагналын алдаа¹-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө, гүйцэтгэл зөрүүтэй илэрхийлсэн 101,373.3
- Улсын төсвийн орлого дутуу тайлагнасан 3,000.0
- Хувь хүмүүсээс авах авлага 300.0 мянган төгрөгийг цалингаас суутгасан дүнгээр жинхэнэ зардал, үр дүн зөрсөн.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй 4,594.6 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн

Аудитаар илэрсэн зөрчилд² зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж, 1 төлбөрийн акт өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Хувь хүний орлогын албан татвартай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2025 оны жилийн эцсээр цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварыг нэгтгэн тооцоогүйгээс нэр бүхий 19 хүнтэй холбоотой 1,340.8 мянган төгрөгийн татварыг илүү хөнгөлсөн, мөн нэр бүхий 4 иргэнтэй холбоотой 261.6 мянган төгрөгийн татварыг дутуу суутгасан нь Хувь хүний орлогын албан татварын хуулийн 23.1.Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт / 0- 6,0 сая төгрөгийн орлогод 0,24 сая төгрөг /дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

¹ Мэдээллийг тусгахгүй орхиодуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Хүүхдийн ирцийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Боловсрол мэдээллийн esis.edu.mn системд илгээсэн 2025 оны 03-12 саруудын хүүхдийн ирцийн тоо мэдээг байгууллагын багш нарын өдөр тутамд хөтөлдөг "бүлгийн ирц бүртгэл"-ийн журналын тоотой тулгахад 5480 хүүхэд өдрөөр зөрүүтэй бүртгэгдсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; " 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; "16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;"; БШУЯ-ны 2020 оны 3/1557 дугаар албан бчиг "Боловсролын салбарын удирдлага мэдээллийн систем"-ийн www.esis.edu.mn цахим системийг ашиглан бүртгэх тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Боловсролын мэдээллийн esis.edu.mn цахим бүртгэлд тухай бүрд мэдээллийг үнэн зөв оруулах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх,

3.2.2 Биет бус хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Dynamic ХХК-ний санхүүгийн программыг санхүү бүртгэлийн ажил гүйлгээний орлого, зарлага, тайлан гаргахад ашиглагдаж байгаа боловч бүртгэлд тусгаагүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; " 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; "16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Dynamic ХХК-ний санхүүгийн программыг данс бүртгэлд бүртгэж авах

3.2.3 Тендерийн махны үнэтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Асудал ХХК нь нийт 663.5 кг махыг нэг бүрийг нь 15,509.7 төгрөгөөр буюу 10,290.7 мянган төгрөгний зардал гаргажээ. Тендерийн үнээр бол 663.5 кг махыг 1 кг тутмыг 11000 төгрөгөөр тооцвол 7,298.5 мянган төгрөг болж нийт 2,992.2 мянган төгрөгөөр тендерээр нийлүүлэх үнийг зөрчжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; " 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; "16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагаанд оролцсон үнийг баримтлан ажиллаж, төсвийг хөрөнгийг үр ашгийг дээшлүүлэн, арвилан хэмнэлттэй үр ашигтай зарцуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс: Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн
	3	4	7	8	9	10
Төсвийн гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн	1.0	101,373.3	1.0	101,373.3	1.0	101,373.3
Орон нутгийн төсвийн орлого дутуу тайлагнасан	1.0	3,000.0	1.0	3,000.0	1.0	3,000.0
Хувь хүмүүсээс авах авлага 300.0 мянган төгрөгийг цалингаас суутгасан дүнгээр жинхэнэ зардал, үр дүн зөрсөн.	1.0	300.0	1.0	300.0	1.0	300.0
Нийт алдааны дүн	3.0	104,673.3	3.0	104,673.3	3.0	104,673.3

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/ Үүнээс:			
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	9	10
ХХОАТ	Жилийн эцэст ХХОАТ-ыг нэгтгэн тооцоогүйгээс илүү, дутуу суутгасан	1	1,602.4	1	1602.4		
Норматив зардал	Асудал ХХК нь нийт 663.5 кг махыг нэг бүрийг нь 15,509.7 төгрөгөөр буюу 10,290.7 мянган төгрөгийн зардал гаргажээ. Тендерийн үнээр бол 663.5 кг махыг 1 кг тутмыг 11000 төгрөгөөр тооцвол 7,298.5 мянган төгрөг болж нийт 2,992.2 мянган төгрөгөөр тендерээр нийлүүлэх үнийг зөрчжээ.	1	2,992.2			1	2992.2
Биет бус хөрөнгө	Боловсрол мэдээллийн esis.edu.mn буюу хүүхдийн ирцийн цахим систем, санхүүгийн тооцоолох ХХК, Dynamic ХХК-ний санхүүгийн программ, программ хангамжийг гэрээ байгуулан ашиглаж тайлант онд төлбөрт 160.0 мянган төгрөгийн зардал гаргасан боловч үндсэн хөрөнгө дансанд ямар ч бүртгэл байхгүй байна.	1				1	160.0
Хүүхдийн ирц	Боловсрол мэдээллийн esis.edu.mn систем дэх ирцийн бүртгэл багш нарын өдөр тутамд хөтөлдөг "бүлгийн ирц бүртгэл"-ийн журнал дахь хүүхдийн тоо 5480 хүүхэд өдрөөр зөрүүтэй бүртгэсэн	1				1	
	Нийт зөрчлийн дүн	4	4,594.6	1	1,602.4	3	3,152.2

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			